

**Петро Матад Лимитэд(цаашид “Петро Матад” эсвэл Компани гэх) –ийн  
Үйл ажиллагааны сүүлийн үеийн мэдээлэл**

Петро Матад одоогийн үйл ажиллагааныхаа талаарх сүүлийн үеийн мэдээлэл болон ирэх саруудад хийхээр санал болгож буй ажлын хөтөлбөрийнхөө дэлгэрэнгүй тоймыг танилцуулахдаа таатай байна.

**Матад ХХ – ДТ-4**

2010 оны 12-р сарын эхээр буюу Монголын өвлийн нөхцлийн хамгийн хүнд үе, оргил хүйтнээс өмнө Компани Давсан Толгой-4 цооног (“ДТ-4”)-ийн өрөмдлөгөө зогсоосон юм. Уг цооногийн гүний хэмжээ 1,271 метр байхад өрөмдлөгийг зогсоосон ба өрмийг горимын дагуу талбайд өвөлжүүлэх ажлыг амжилттай хийсэн болно.

Компани болон түүний өрөмдлөгийн ажлыг гэрээгээр гүйцэтгэгч “Ди Кью И Интэрнэйшнл” нар ДТ-4 цооногийн өрөмдлөгийг 4-р сард дахин эхлүүлэхээр зорин ажиллаж байна. Уг цооногийг 2,020 метрийн тооцоолсон гүн хүртэл босоо чиглэлээр өрөмдөж байгаа юм. 2011 онд нэмж өрөмдөх цооногууд нь доор дурьдагдах 3 хэмжээст сейсмийн дахин тайлалын үр дүнд тулгуурлах болно.

ДТ-4 цооногийн өрөмдлөгөөс гадна, 2010 онд өрөмдсөн цооногуудад хийхээр төлөвлөсөн туршилтын хөтөлбөрт мөн ахиц гарсан. Өрмийн үйлчилгээний цамхаг болон холбогдох тоног төхөөрөмжийг бэлдэх болон гэрээлэгчдийг сонгох ажил хийгдэж, туршилтын хөтөлбөрийг 5-р сард буюу өдөр, шөнийн аль аль нь нэмэх хэмд хүрмэгц эхлүүлэхээр тооцоолоод байна. Туршилт хийхээр төлөвлөж буй эхний цооног бол ДТ-1 юм.

***Матад ХХ талбайн сейсмийн гэрээ***

Компани нь геофизикийн судалгааны “Би Жи Пи Инк” (“BGP Inc”) компаниар Матад ХХ талбайд нийт 1000 км урт 2 хэмжээст сейсмийн судалгааг хийлгэхээр сонгосон. Тус судалгаа нь талбайн хойд хэсгийн сейсмийн судалгаа бага хийгдсэн хэтийн төлөв бүхий хэсгүүд ба хэтийн төлөв сайтай хэсгүүдэд гүйцээж сейсмийн судалгаа хийх ба талбайн төв болон урд хэсгийн 6 хотгорыг хамарсан өргөн хүрээтэй хайгуулын ажлуудаас бүрдэх юм.

ДТ-1, ДТ-2 болон ДТ-3 цооногуудын тосны илрэл нь Матад ХХ талбайд тогтоогдсон тосны тархацыг талбайн урд зүг рүү мэдэгдэхүйц зайд нэмэгдүүлээд байна. Энэхүү 2 хэмжээст сейсмийн хөтөлбөрийг Матад ХХ талбайн өмнөд болон төв хэсэг дэх дэд сав газар дахь нүүрсустөрөгч үүсэх болон шилжих шинэ системийг шалгахад зориулж боловсруулсан юм.

Компани өмнө нь “Би Жи Пи Инк”-тэй хамтарч ажиллаж байсан ба, хамгийн сүүлд буюу 2008 онд Матад ХХ талбайн Давсан Толгой төсөл дээр 3 хэмжээст сейсмийн судалгааг тэд гүйцэтгэсэн юм. “Би Жи Пи Инк” одоо техник тоног төхөөрөмж болон хүн хүчээ зөөвөрлөж байгаа ба хээрийн ажил ойрын хэдэн өдрийн дотор эхэлж, 6-8 долоо хоногийн дотор дуусгахаар төлөвлөж байна. Хэрэв шаардлагатай гэж үзвэл нэмэлт судалгаа хийж болох талаар гэрээнд тусгагдсан болно.

***Богд IV, Онги V талбай- Давхрагазүйн өрөмдлөг ба Хайгуулын ажлын явц***

Монголын төв хэсэгт оршдог Богд IV, Онги V талбайн давхрагазүйн өрөмдлөгийн ажлыг гүйцэтгүүлэхээр Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй “Мэйжор Дриллинг Групп Интэрнэйшнэл”-д Петро Матад захиалга өгөөд байна. 2010 онд Петро Матадын хийсэн 2 хэмжээст сейсмийн шугамуудын нэг дээр байрлаж буй эхний цооногоос хамгийн багадаа 1500 метр урт үргэлжилсэн чөмөг чулуун дээж авах юм. Давхрагазүйн өрөмдлөгийн зорилго нь сейсмийн судалгаагаар гарсан үр дүнг тулгуур мэдээллээр хангах ба давхрагын дулааны өөрчлөлтийг шууд хэмжих явдал юм. Өрөмдлөг 3-р сарын 7-нд эхэлсэн ба нэг цооногт 6-8 долоо хоног зарцуулах төлөвтэй байна. Дээр дурдсан зорилгуудыг биелүүлэхэд тус болохуйц,

газрын тосны ямар нэг хайгуулын ажил урьд нь хийгдэж байгаагүй тул, давхрагазүйн өрөмдлөг бол Компанийн Богд IV, Онги V талбай хийх хайгуулын ажлын чухал алхам юм.

Богд IV, Онги V талбайд 2010 онд хийгдсэн геологи, геофизикийн хөтөлбөрийн үр дүнд тайлал хийх ажлыг энэ өвөл хийлээ. Өмнө нь байсан болон шинээр хийсэн эрдэм шинжилгээний ажлууд дээр нэмээд, Компани өөрийн хайгуулын багаас гадна хээрийн экспедицид ажилласан зөвлөх мэргэжилтнүүдийн оролцоотойгоор геологийн өргөн хүрээтэй хээрийн ажлыг хийгээд байна. Бид өмнө нь улсын төсвөөр 19,324 цэг дээр хийгдсэн хүндийн хүчний хэмжилт дээр нэмж, 2010 онд 4500 шинэ цэгээс мэдээлэл авсан. Ингэснээр хүндийн хүчний судалгааны цэгийн торлолыг хоёр талбайд жигд болгосон юм.

Монголын төвийн бүс дэх анхны сейсмийн судалгааг мөн 2010 онд хийсэн. Богд IV талбайд сейсмийн 3 шугам, Онги V талбайд 4-ийг, нийт 349 тууш километр урт 2 хэмжээст сейсмийн судалгааг хийгээд байна. Хүндийн хүчний болон сейсмийн мэдээллүүдийг геологийн мэдээллүүдтэй нийцүүлэн боловсруулж, тайлал хийсэн урьдчилсан үр дүн нь Төв Азийн хувьд нүүрсустөрөгч үүсэх үндсэн систем болсон Цэрдийн үеийн тэгш бүс хэмт сав газар байгааг тодорхой харуулж байна.

Хээрийн геологийн судалгаа, хүндийн хүчний болон сейсмийн нэгдсэн судалгааны үр дүн нь хоёр талбай хоёулаа их хэмжээний нүүрсустөрөгчийг үүсгэж, хураасан үүсгэх, агуулах, таглахад тохиромжтой зузаан давхрагуудын дараалалыг агуулж байна гэсэн Компанийн анхны таамаглалыг баталж байна. Эдгээр нь Монголын бусад нутагт олдсон бүтцийн болон давхрагазүйн тос үүсэх системийн төрлүүдтэй илүү нийцэж байгаа юм.

Богд IV, Онги V талбайн мэдээллийн тайлалыг гүйцэтгэсний дараа, холбогдох үр дүнгийн тоймыг зарлах ба, Богд IV, Онги V талбайд 2011 онд хийх хайгуулын ажлын хөтөлбөрийг эцсийн байдлаар хийж дуусгана.

#### *Компанийн бүрэлдэхүүнд Өрөмдлөгийн Тасгийг Байгуулав*

Компани нь Хайгуулын Тасагтайгаа хослуулахын тулд өөрийн Өрөмдлөгийн Тасгийг байгуулаад байна. Өрөмдлөгийн Тасгийг Газрын тосны инженерийн шинжлэх ухааны бакалавр, бизнесийн удирдлагын магистр Марк Зэбровиц удирдаж байна. Зэбровиц олон улсын хайгуул, ашиглалт болон төслийн удирдлагын хүрээний 25 жилийн туршлагатай бөгөөд санхүү, аюулгүй ажиллагаа, өрөмдлөг/байгууламж/олборлолтын үйл ажиллагааны төрөл бүрийн салбарт мэргэшлийн дагуу ажилласан туршлагатай нэгэн юм. Монгол Улсын газрын тосны салбарын үндэсний чадавхыг бий болгоход идэвхтэй туслах гэсэн Компанийн зорилгод нийцсэн техникийн боловсон хүчнийг хөгжүүлж удирдах өргөн туршлага Зэбровицэд бий. Рэгал Петролиум, Ти Эн Кей-Би Пи (ТНК-ВР) болон Нэйшнс Энержи (Азербайжан) дэх сүүлийн үеийн туршлага нь Монгол дахь өрөмдлөгийн үйл ажиллагаанд ихээхэн тус болох юм.

Компани нь мөн шинжлэх ухааны бакалавр (Газрын тосны Геологи) Еэрл Эдмондсийг Өрөмдлөгийн Хэлтсийн Үйл ажиллагааны Геологийн Менежерээр томилсон. Эдмондс нь загварчлах, үйл ажиллагаа, ашиглалтын геологи болон газрын тос, байгалийн хийн ордын менежментийн салбарт 20 жил ажилласан туршлагатай мэргэжилтэн юм. Эдмондс бол ордын ашиглалт, усны шахалтын менежмент, өрөмдлөг, цооногийн үйлчилгээний цамхаг, болон цооногийг тоноглох хөтөлбөрүүд зэргээр дагнасан мэргэшлийн өргөн туршлагатай нэгэн юм.

#### *Давсан Толгой 3 Хэмжээст Сейсмийн Судалгааны засвар тайлал.*

Давсан Толгойн гүдэн бүтэц дээр өрөмдсөн 3 цооногийн гурав дахь нь болох ДТ-3-ийг 2010 онд өрөмдөж дууссаны дараа Петро Матад компани Давсан толгойд хийсэн 135 кв.км 3 хэмжээст болон түүний эргэн тойронд хийсэн 2 хэмжээст сейсмийн судалгааны мэдээллийг дахин боловсруулж, зураг зохиож байна.

Давсан Толгойн бүтцийн болон давхрагазүйн бүрэлдэхүүнийг тус хэтийн төлөв сайтай талбайн эзэлхүүн болон эрсдлийн хүчин зүйлүүдтэй уялдуулан бүрэн шинжлэхийн тулд 2010 онд өрөмдсөн 3 цооногийн мэдээллийг урьд нь байсан болон нэмэлт шинэ мэдээлэлтэй нэгтгэсэн. Дахин тайлалын ажил одоогоор үргэлжилж байгаа бөгөөд үр дүн нь Компанийн 2011 оны өрөмдлөгийн хөтөлбөрийг төлөвлөхөд чухал хүчин зүйл болох төлөвтэй байна.

“Өнгөрсөн 3 сарын турш Компанийн хайгуулын үйл ажиллагаа болон удирдлагын түвшний аль алинд нь ихээхэн ахиц дэвшил гаргасан” гэж Ерөнхий Гүйцэтгэх Захирал (ЕГЗ) Даглас Макгей хэлэв. Өрөмдлөгийн Тасгийг байгуулсан нь Петро Матадыг хөгжүүлэх бас нэг алхам болсон юм. Бид энэхүү өргөжилтийг тэргүүлж буй Зэбровиц болон Эдмондс нарын удирдлагын багтай болсондоо туйлын баяртай байна. Энэ тасаг манай өрөмдлөгийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалт, хангамж болон хяналтаар хангаж ажиллах юм. Энэ бол газрын тосны хайгуулын олон улсын стандартыг өөрийн орондоо бий болгож байгаа Монголын газрын тосны салбар дахь бас нэг анхны алхам юм. “Бид Монголын хүнд хэцүү өвлийн эхлэл төгсгөл дээр хээрийн хайгуулын үйл ажиллагаагаа явуулж байгаагаа тэмдэглэх хэрэгтэй. 2010 онд бид цооногоо өвөл эхэлсний дараа өрөмдсөн бөгөөд 2011 онд өвөл дуусахаас өмнө, өрөмдлөг болон сейсмийн судалгаагаа эхэлж байна. Компани нь Монголын газрын тосны хайгуулын түүхэнд анх удаа бүтэн жилийн турш ажиллахаар зорьж байна.

“Компанийн болон захиргааны чадавхийг нэмэгдүүлж, өөрийн техникийн мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлж байгаа нь Петро Матад компани 2011 онд идэвхтэй, үр бүтээлтэй хөтөлбөр хэрэгжүүлэх үндэс суурийг тавьж байна.”

Энэхүү мэдээллийн техниктэй холбоотой хэсгийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүган хянасан болно. Доктор Күүган нь Хойд Америкийн болон олон улсын хайгуулын болон ашиглалтын чиглэлээр 29 жил ажилласан туршлагатай, газрын тосны геологич юм. Тэрээр Газрын тосны Геологичдын Америкийн Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

#### Петро Матад Лимитед компанийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 хавтгай дөрвөлжин километр талбай бүхий газрын тосны ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 хавтгай дөрвөлжин километр талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Айл эф Мэн (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Дуглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

#### **Петро Матад Лимитэд**

Ерөнхий Гүйцэтгэх Захирал - Даглас Жэй МакГэй (Douglas J. McGay)  
+976 11 331099

#### **Уэстхауз Секьюритиз Лимитэд**

Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)  
+44 (0)20 7601 6100